

“БӨХӨГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04-р сарын 25-ны өдөр

№01

Улаанбаатар хот

Компанийн 2016-2017 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, “Бөхөг” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.А хэсгийн 7.8.3 дахь заалт болон 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Бөхөг” Хувьцаат компанийн 2016-2017 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс оруулсан дүгнэлтийг хэлэлцээд тус компани өнгөрсөн онд үйл ажиллагааг эхлүүлэх санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхээр төсөл боловсруулан, техник технологийн шинэчлэлийн судалгааг хийж, бусдад төлөх өр төлбөрийг төлөх талаар тодорхой ажлуудыг төлөвлөн, амжилттай хэрэгжүүлж ажилласныг тэмдэглэж “Бөхөг” Хувьцаат компанийн 2017 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.ЧАНЦАЛ

“БӨХӨГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04-р сарын 25-ны өдөр

№02

Улаанбаатар хот

Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон бизнес төлөвлөгөөг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь хэсэг, “Бөхөг” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.А хэсгийн 7.8.8 дахь заалт болон 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон бизнес төлөвлөгөөг *Хавсралт*-аар баталсугай;
2. Энэ тогтоол, тогтоолын хавсралтаар баталсан бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг Гүйцэтгэх захирал /Ц.Ганцэцэг/-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /М.Норов/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.ЧАНЦАЛ

“БӨХӨГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04-р сарын 25-ны өдөр

№03

Улаанбаатар хот

Их хэмжээний хэлцэл хийх асуудлаар ТУЗ-д эрх олгох эсэх тухай

Монгол улсын компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь хэсэг, 62.1.10 дахь хэсэг, “Бөхөг” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.А хэсгийн 7.7.3 дахь заалт, болон 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, шинэ технологи нэвтрүүлэхтэй холбоотой санхүүхийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор гадаадын хөрөнгө оруулагчидтай их хэмжээний хэлцэл хийх эрхийг ТУЗ-д олгосугай.
2. Их хэмжээний хэлцэл хийхтэй холбоотой ажлыг эрхлэн гүйцэтгэх, хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /М.Норов/, Гүйцэтгэх захирал /Ц.Ганцэцэг/-т тус тус хариуцуулан даалгасугай.
3. Их хэмжээний хэлцэл, түүнтэй холбогдох бүртгэл, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг хэрэгжүүлж, зохих бичиг баримтыг “Санхүүгийн зохицуулах хороо”, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК болон бусад холбогдох газруудад хуульд заасан хугацаанд, зохих журмын дагуу бүртгүүлэх, хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал /Ц.Ганцэцэг/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.ЧАНЦАЛ

“БӨХӨГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04-р сарын 25-ны өдөр

№04

Улаанбаатар хот

Ногдол ашиг тараах эсэх талаархи ТУЗ-ийн тогтоолыг хэлэлцэж батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6 дахь хэсэг, “Бөхөг” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.Б хэсгийн 7.32.10 дахь заалт, 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Бөхөг” Хувьцаат компанийн 2017 оны 4 дүгээр улирлын санхүүгийн тайланг судлан үзсэний үндсэн дээр Ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 03-р сарын 06-ний өдрийн №02 тоот тогтоолыг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.ЧАНЦАЛ

“БӨХӨГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04-р сарын 25-ны өдөр

№05

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Бөхөг” ХК-ийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтүүдийг Хавсралт 1 ёсоор баталсугай.
2. Компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа дагаж мөрдсүгэй

ХУРЛЫН ДАРГА



Ц.ЧАНЦАЛ

“БӨХӨГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04-р сарын 25-ны өдөр

№06

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргыг шинэчлэн батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.1, 77.4 дэх заалтуудыг тус тус удирдлага болгон 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Бөхөг” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Магсар-овогтой Норовыг үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.
2. “Бөхөг” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргаар Цогт овогтой Чанцалыг томилон ажиллуулах саналыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд хүргүүлсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Ц.ЧАНЦАЛ

“БӨХӨГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04-р сарын 25-ны өдөр

№07

Улаанбаатар хот

Өмчийн тооллого болон хөрөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулах тухай

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, СТОУС 16-ын 32, 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Бөхөг” ХК-ийн өмчийг тооллого хийж, коджуулах ажлыг зохион байгуулсугай.
2. Цэвэр, бохир усны байгууламжид үйл ажиллагаа явуулж буй холбогдох байгууллагын үйл ажиллагааг 2018 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөр тасалбар болгон зогсоож чөлөөлөх тухай мэдэгдлийг хүргүүлсүгэй.
3. Өмчийн маргаантай байгаа гал унтраах ангийн ашиглаж буй компаний байрыг чөлүүлэх ажлыг хуулийн дагуу гүйцэтгэж компаний өмчид бүртгэсүгэй.
4. Өмчийн өөрчлөлтийг санхүүгийн тайланд тусган ажиллахыг нягтлан бодогч (Р.Дархижав)-д даалгасугай.
5. Санхүүгийн тайланг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хуулийн хугацаанд хүргүүлсүгэй.
6. Тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ц.Ганцэцэг)-д үүрэг болгосугай.
7. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавин ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (М.Норов)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.ЧАНЦАЛ

“БӨХӨГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04-р сарын 25-ны өдөр

№08

Улаанбаатар хот

ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын Хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Компанийн дүрмийн 7.8.7 дах заалт, 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Бөхөг ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалинг оролцоонд үндэслэсэн цалингаар тогтоосугай.
2. ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг Хавсралт 1 ёсоор тогтоосугай.
3. ТУЗ-ийн гишүүдийн оролцооны цалинг Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурал, ТУЗ-ийн дэргэдэх хороодын хуралд оролцсон оролцоонд үндэслэн, хагас жилд нэг удаа олгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.ЧАНЦАЛ